



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2021 оны 12 сарын 02 өдөр

Дугаар 548

Улаанбаатар хот

**Хөрөнгө, өр төлбөр бүртгэх зөвшөөрөл
олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дах заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.1.2, 4.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Дэлхийн банкны “Эрчим хүчний төсөл-2”, Орхон аймгийн Баян-Өндөр сумын нутагт байрлах 35/6 кВ-ын МВА чадалтай ЦРП-8 дэд станц шинээр барих ажлын хүрээнд бий болсон 3,169,286,816.63 (гурван тэрбум нэг зуун жаран есөн сая хоёр зуун наян зургаан мянга найман зуун арван зургаан төгрөг жаран гурван мөнгө) төгрөгийн үнэ бүхий хавсралтад заасан хөрөнгө, холбогдох өр төлбөрийг “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид бүртгэхийг зөвшөөрсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Насантогтох, “Эрдэнэт-Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал В.Адъяа нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө, өр төлбөрийг Сангийн яамтай тооцоо нийлэн хүлээн авах, хүлээлцэх, тооцоо нийлэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2.Хөрөнгө өр төлбөрийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3.Арга хэмжээний биелэлтийг 2022 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

132001457

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 12 дугаар сарын 2-ны өдрийн
СХД дугаар тогтоолын хавсралт

"ЭРДЭНЭТ-БУЛГАНЫ ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ҮНДСЭН ХӨРӨНГӨД
БҮРТГЭХ ХӨРӨНГӨ ӨР ТӨЛБӨРИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр төрөл	Гүйцэтгэгч компани болон төслийн оролцогч	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Хуваарилах төсөвт өртгийн дүн, USD	Нэгжийн үнэ, USD	Эрдэнэт 35/6 кВ- ын 2*10 МВА дэд станц	6 кВ-ын ЦДКШ	220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын 35 кВ-ын гаргалгаа
1	Эрдэнэт 35/6 кВ-ын 2*10 МВА дэд станц	Дахот ХХК, Катодгал ХХК	ком	1	-	1,027,780.62	2,477,365,211.00	0.00	0.00
2	6 кВ-ын ЦДКШ	Дахот ХХК, Катодгал ХХК	км	0.88	-	0.00	0.00	82,272,985.00	0.00
3	220/110/35/6 кВ-ын Эрдэнэт дэд станцын 35 кВ-ын гаргалгаа	Дахот ХХК, Катодгал ХХК	ком	2	-	0.00	0.00	0.00	254,079,963.00
4	Даатгалын зардал	Дахот ХХК, Катодгал ХХК	MNT	0	37,240,229.00	0.00	32,788,517.74	1,088,902.52	3,362,808.74
5	Барилга угсралтын ажлын зураг төслийн зохиогчийн хяналтын ажлын өртөг	Бодит чадал ХХК	MNT	0	28,509,584.00	0.00	25,101,537.39	833,618.88	2,574,427.73
6	Зээлийн хүүгийн хуримтлагдсан зардал	Сангийн Яам	USD	0	27,821.67	0.00	69,804,136.07	2,318,186.52	7,159,151.28
7	Ашиглагдаагүй зээлийн хүү	Сангийн Яам	USD	0	10,365.80	0.00	26,007,619.27	863,709.74	2,667,355.99
8	Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардал (төсөвт өртгийн дүнгийн 8.24%)	ЭХТ-2 төслийн нэгж	USD	0	539,582.40	44,461.59	111,553,423.40	3,704,675.07	11,440,981.56
9	Чадавх бэхжүүлэх сургалтын зардал (төсөвт өртгийн дүнгийн 8.24%)	ЭХТ-2 төслийн нэгж	USD	0	231,249.60	19,054.97	47,808,610.03	1,587,717.89	4,903,277.81
Дүн						Дүн	2,790,429,054.91	92,669,795.62	286,187,966.10
Нийт дүн						3,169,286,816.63			
						нэг зуун жаран есөн сая хоёр зуун наян зургаан мянга найман зуун арван зургаан төгрөг жаран гурван мөнгө)			